Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ А.ОЮУНСУВДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 11 дүгээр сарын 12

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛГО: УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.** /"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 он стратеги төлөвлөгөө/ | | | | | | | |
| **Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | |
| 1.1 | Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх | Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо | 6 | 7 | 1. 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хэлтсийн хаалттай групп дээр тавигдсан УБЕГ-ын 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөнд google forms-оор дамжуулан саналаа хүргүүлсэн.<br>2. Аймгийн хүүхэд, гэр бүл, Залуучуудын хөгжлийн газраас "2024 оны гэр бүл хөгжлийн жил" болгосонтой холбогдуулан гэр бүлийн хөгжилд жендэрийн харилцааг илүүтэй дэмжих талаар санал хүргүүлсэн.<br>3. 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр УБЕГ-аас хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой сургалтын санал авч хугацаанд нь хариу хүргүүлсэн. | 01-11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. УБЕГ-аас ёс зүйн хороо байгуулахтай холбоотой хэлтсээс албан хаагчын нэр явуулах саналд Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр -ыг дэмжиж санал хүргүүлсэн.<br>5. Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 14 дүгээр зүйл, аймгийн 2024 оны "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн төлөвлөгөөнд дараах саналыг хүргүүлсэн. Үүнд:<br>➢ Аймгийн Жендэрийн салбар хороотой хамтран идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудаас сард 1 байгууллагыг сонгон тухайн байгууллагын албан хаагчдын гэр бүлд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь гэр бүлийн харилцаанд хэрхэн нөлөөлөх талаар мэдээлэл өгөх өдөрлөг, сургалт зохион байгуулах /Жич: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс/<br>➢ Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хамруулсан байгууллага болон гэр бүлийн тоо<br>➢ 2024 оны аймгийн жендэрийн салбар хорооны төсөвд суугдсан санхүүжилтээс тодорхой хэмжээгээр санхүүжигддэг байх.<br>6. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хяналт шалгалтын газрын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 91 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн санал авах тухай албан бичгийн биелэлтийн талаар:<br>Дээрх албан бичгийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр дараах саналыг хүргүүлж ажилласан. Үүнд:<br>➢ Үйлчилгээний төрөл сольж болдог байх<br>➢ Яаралтай төлөв хасах<br>7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 9/12988 дугаарт албан бичгээр ирүүлсэн “Хүүхдийн төлөө” аяны удирдамжийн дагуу хэлтсийн хамт олонтойгоо тус аянд нэгдсэнээ илэрхийлж гарын үсгээр баталгаажуулан хэлтсийн даргаар дамжуулан хүргүүлсэн. | | |
| 1.2 | Улсын бүртгэлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар холбогдох газруудаас мэдээлэл авах, иргэдэд улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжийн талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, мэдлэг олгох зорилгоор цахим, фейсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах | Хэлтсийн Face хуудсаар оруулсан мэдээллийг түгээсэн тоо | 371 | 463 | 1. УБЕГ, АЗДТГ, АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, болон өөрийн байгууллагын талаар цаг үеийн үйл ажиллагааг сурталчилсан нийт 463 мэдээллийг өөрийн цахим хуудсандаа цаг тухай бүр нь шэйр хийж олон нийтэд түгээх ажилд оролцож улмаар дээрхи цахим хуудаснуудаас долоо хоног бүрийн олон нийтийн оролцооны жагсаалтад байнга багтаж хамгийн идэвхитэй дагагчдын нэг байгаа гэсэн үнэлгээг авсаар ирсэн. | 01-11 | 100% |
| | | Аймгийн ЗДТГ-ын холбогдох газар, хэлтсүүдээс цахим хуудсаар дамжуулан оруулсан мэдээллийг олон нийтэд түгээсэн тоо | 200 | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өөрөө мэдээлэл бэлтгэн оруулсан тоо | 2 | 5 | 1. 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль Эрх зүйн хэлтсээс 2024 оны 01 дүгээр сарын 13-ны Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан заасан заалтыг уншиж олон нийтэд хүргэсэн.<br>2. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа банк, банк бус санхүүгийн байгууллагатай хамтын үйл ажиллагааг сайжруулах хамтарсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан талаар хэлтсийн face хуудсаар мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн.<br>3. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 2/11313 тоот “Биелэлт ирүүлэх тухай“ албан бичгийн дагуу “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг хөвгүүд, эрчүүдийн оролцоог хангах замаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэж, хүчирхийллийг таслан зогсоох, түүнчлэн урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжид заасан санаачлагыг дэмжин, дараах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээг зохион байгуулсан талаар мэдээлэл түгээсэн.<br>4. 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдөр Сүлжээний инженер Р.Доржнямбуу, Улсын бүртгэгч З.Дуламсүрэн нарын хамт явуулын үйлчилгээг Номгон ахлах сургууль дээр очиж үзүүлсэн.<br>5. 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр тасгийн дарга хурал хийж танхимаар хамрагдсан бөгөөд тасгийн даргын өгсөн үүрэг даалгаварын дагуу Бямба гариг хөтөлбөр болон барьцааны гэрээг өдөрт нь бүртгэх болсонтой холбогдуулан контент хийж цахимаар түгээсэн. | | |
| 1.3 | Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машинаар авах | Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо | 1 585 | 1759 | 1. Хэлтсийн байранд Төрийн банкны пос машин байршуулсанаар иргэдэд түргэн шуурхай цаг алдалгүй үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн нийт 1374 бүртгэлийн 29 705 554 төгрөгийг карт уншуулан тушаалгасан байна.<br>2. Хэлтсийн үйлчилгээний зааланд цахим КИОСОК машин болон E-mongolia төхөөрөмж байршуулсанаар иргэд тоон гарын үсэг, интернэт банк, нэг удаагийн код зэргийг ашиглан бүх төрлийн лавлагаа, хуулбар мөн нэхэмжлэлийн дугаар үүсгэн тэмдэгтийн хураамжыг орон зай цаг хугацаа харгалзалгүй нийт 385 иргэн түргэн шуурхай авах боломж бүрдсэн. | 01-11 | 100% |
| **Зорилт 2. Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх | Бүртгэлийн тоо | 2 819 | 2 655 | 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 2655 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалсан.<br>***Анхны бүртгэл нийт 187 бүртгэгдсэнээс:***<br>✓ Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулах - **97**<br>✓ Газраас бусад ҮХЭХ-ийг анх удаа бүртгэж баталгаажуулах **- 30**<br>✓ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах - **45**<br>✓ Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх **- 15**<br>***Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл нийт 294 бүртгэгдсэнээс:***<br>✓ Худалдах, худалдан авах гэрээ - **233**<br>✓ Бэлэглэх гэрээ - **8**<br>✓ Арилжих гэрээ **- 2**<br>✓ Өв залгамжлал - **17**<br>✓ Хамтран өмчлөгч өөрчлөгдөх **- 1**<br>✓ Эд хөрөнгийн үнэ, өмчлөгчийн овог нэр өөрчлөгдөх **- 1**<br>✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх **- 21**<br>✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээ худалдах **– 8**<br>✓ Өмчлөгч өөрт ногдох хэсгээс бэлэглэх **- 3** | 01-11 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ***Эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл нийт 113 бүртгэгдсэнээс:***<br>✓ Эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх - **58**<br>✓ Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх - **1**<br>✓ Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх - **21**<br>✓ Өмчлөгчийн овог нэр, регистер өөрчлөгдөх – **5**<br>✓ Газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх - **1**<br>✓ Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх – **12**<br>✓ Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох - **5**<br>✓ Жагсаалтаар салж бүртгэгдэж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх - **10**<br>***Барьцааны гэрээ болон дуусгавар нийт 2061 бүртгэгдсэнээс:***<br>✓ Барьцаалбартай барьцааны гэрээ – **366**<br>✓ Барьцаалбаргүй барьцааны гэрээ – **547**<br>✓ Барьцаалбартай барьцааны гэрээний өөрчлөлт - **4**<br>✓ Барьцаалбаргүй барьцааны гэрээний өөрчлөлт – **3**<br>✓ Барьцааны гэрээний дуусгавар – **964**<br>✓ Барьцааны үүргийн зарим хэсэг дуусгавар болох – **69**<br>✓ Архивын лавлагаа – **33**<br>✓ Хуулбар – **46**<br>✓ Хувийн хэрэг хаах – **29** | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэх | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй болон алдаатай орсон мэдээллийг засуулахаар улсын ахлах бүртгэгчид өгсөн тоо<br>Засагдсан тоо | 9 | - | 1. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахимжсан хувийн хэргүүдэд үйлчилгээ хийхдээ нотлох баримтын дараалал болон дугаарлалтыг шалгаж алдаатай байгаа хувийн хэргийг тухай бүр нь захиалгын хуудсаар архиваас татан авч /Хувийн хэргийн буцаалт хийлгүүлж, зөрчил арилгуулах тухай/ дүгнэлтийн хуудас үйлдэн тасгийн даргаар батлуулж, хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан дахин цахимжуулж нийт 3 ширхэг хувийн хэргийн зөрчлийг арилган ажиллаа.<br>2. Бүртгэлийн явцад цахим мэдээллийн сан болон цаасан нотлох баримт хоорондоо зөрүүтэй байсан буюу алдаатай хувийн хэргүүдийг засуулахаар тасгийн даргад архивчаар дамжуулан жагсаалтаар нийт 18 нотлох баримтыг хүлээлгэн өгсөн. | 01-11 | 100% |
| 2.3 | Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх | Иргэнд олгосон тоо | 5 | 8 | 8 иргэн мэдүүлэг гаргаж лавлагаа олгосон байна. | 01-11 | 100% |
| | | Хуулийн этгээдэд олгосон тоо | 15 | 25 | 25 хуулийн этгээд мэдүүлэг гаргаж лавлагаа олгосон байна. | | |
| | | Хууль хяналтын байгууллагад олгосон тоо | 98 | 96 | Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд заасанаар хуулийн байгууллагын албан бичиг, нийт 96 ирсэнээс:<br>✓ УБЕГ-аас - 1<br>✓ Цагдаагийн тогтоол – 59<br>✓ Баянхонгор аймгийн ИХАШШүүх – 6<br>✓ Баянхонгор аймгийн Прокурорын газар – 4<br>✓ Баянхонгор аймгийн ШШГГ – 12<br>✓ Нийслэлийн ШШГГ – 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ✓ ШШГЕГ – 1<br>✓ АТГ – 10<br>Дээрх албан бичгийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 612 газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгөний өмчлөгчийн талаарх мэдээллийг өгсөн байна. | | |
| 2.4 | Сумын бүртгэгч нараас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдүүлэг нотлох баримтыг хүлээн авч бүртгэн баталгаажуулах ажлыг үргэлжлүүлэх | Сумын улсын бүртгэгч нараас хүлээж авсан мэдүүлэг нотлох баримт ирүүлсэн тоо | 50 | 18 | 1. Галуут сум – 10<br>2. Баянцагаан сум – 7<br>3. Баацагаан – 1 | 01-11 | 95%<br>50% |
| | | Хуулийн шаардлага хангасан мэдүүлэг нотлох баримтыг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн тоо | 42 | 15 | 1. Галуут сум – 9<br>2. Баянцагаан сум – 6 | | |
| | | Шаардлага хангаагүй нотлох баримтыг буцаасан тоо | 8 | 3 | ✓ Шаардлага хангаагүй нотлох баримт татгалзсан бүртгэл - 3 | | |
| 2.5 | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн өөрчлөлтийг бүртгэн баталгаажуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн хаяг өөрчлөгдсөн бүртгэлийн тоо | 203 | 196 | ✓ Дангаараа эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл – **18**<br>✓ Өөр бүртгэлтэй давхардсан бүртгэлээр эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл – 178 | 01-11 | 95%<br>89,04 |
| | | Шинээр нэмж оруулсан хаягийн тоо | - | 18 | ✓ Шинээр нэмж оруулсан хаягийн тоо - 18 | | |
| **Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан болон цаасан нотлох баримтын баяжилтыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу хийж өдөр тутамдаа архивчид хүлээлгэн өгөх | Бүртгэлийн эх нотлох баримтыг цаасаар бүрдүүлж, цахим мэдээллийн санд оруулан өдөр бүр архивчид хүлээлгэн өгсөн бүртгэлийн тоо | 2819 | 2 685 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг архивт хүлээлгэн өгөх дэвтэрийн дагуу хөтлөж нийт 2685 бүртгэлийн мэдүүлэг нотлох баримтыг өдөр бүр архивчид хүлээлгэн өгч ажилласан. | 01-11 | 95% |
| | | Бүртгэлийн хуудасны тоо | 11000 | 15 453 | Бүртгэлийн хуудасны тоо - 15453 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | Хэлтсийн даргын баталсан "Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө-2024" – ний дагуу сургалтад хамрагдах | Мэдлэг мэдээлэл олгох сургалтад хамрагдсан хувь | 95% | 60% | 1. 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал дараах мэдээлийг хүргэсэн. Үүнд:<br>✓ УБЕГ-ын 2024 оны төлөвлөгөө<br>✓ Хэлтсийн 2024 оны төлөвлөгөө<br>✓ 2024 оны 01-р сарын хэлтсийн албан хаагчдын ирц, цагийн бүртгэл, идэвхи оролцоо<br>✓ Төрийн архивын шалгалт<br>✓ Орон нутгийн удирдлагуудын шуурхай дээр өгсөн мэдээллээс онцолсон.<br>2. 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч. Насан туршийн боловсролын төвөөс мэргэжилтэн С.Отгонцэцэг "Зорилгоороо удирдуулах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж хамрагдсан.<br>3. 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хэлтсийн мэдээллийн цагаар Насан туршийн боловсролын төвөөс сургагч багш П.Дайрийсүрэн "ЕМРАТҮ-БУСДЫГ МЭДЭРЧ, ОЙЛГОХ ЧАДВАР" сэдэвт сургалтыг зохион байгуулж хамрагдсан.<br>4. 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хэлтсийн мэдээллийн цагаар Насан туршийн боловсролын төвөөс "Минималист амьдралын хэв маяг" сэдэвт сургалт, хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал "Төрийн албан | 01-11 | 100%<br>90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчын ёс зүйн тухай хууль" батлагдсан холбоотой ёс зүйн хороо байгуулах санал хүргүүлэх талаар, бүртгэгч З.Дуламсүрэн "Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны үйлчилгээний стандартыг мөрдөх нь" сэдэвт сургалт зохион байгуулж хамрагдсан.<br>5. 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хэлтсийн мэдээллийн цагаар Насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэн "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо" сэдвээр сургалт зохион байгуулж, хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал цаг үеийн асуудлаар мэлээлэл өгч хамрагдсан.<br>6. 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль"-иар, архивч Дашням "Архив, албан хэрэгхөтлөлтийн тухай хууль"-иар тус тус сургалт зохион байгуулж хамрагдсан.<br>7. 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр Төрийн албан хаагчын анкетыг шинэчлэн хэлтсийн дарга Ц.Мөнхжаргалд хүлээлгэн өгсөн.<br>8. 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал цаг үеийн асуудлаар мэдээлэл өгсөн.<br>9. 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хэлтсийн мэдээллийн цагаар Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан "Миний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрүүл мэнд миний гарт" сэдэвт сургалтад танхимаар хамрагдсан.<br>10. 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал цаг үеийн мэдээллээр, улсын бүртгэгч Д.Мягмар "Төрийн албан хаагчын ёс зүйн хэм хэмжээ" сэдвээр тус тус сургалт мэдээлэл өгч танхимаар хамрагдлаа. | | |
| 4.2 | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулсан сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан хувь | 100% | 100% | Хүний нөөц, сургалтын нэгдсэн системийн бие даах хичээлийг бүрэн судлаж, бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. | 01-11 | 100% |
| 4.3 | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан тоо | 2 | 2 | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 2 удаа хамрагдаж, аймгийн нэгдсэн эмнэлэгт хэлтсийн дарга болон хамт олны тусламжтайгаар 2 удаа хэвтэн эмчлүүлсэн байна. | 01-11 | 100% |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.4 | Хууль тогтоомжийн дагуу холбогдох мэдээ тайлан хүргүүлсэн тоо | Хугацаанд нь хүргүүлсэн тоо | 12 | 6 | УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас өгсөн зөвлөмжийн дагуу 2023 оны 10 дугаар сараас эхлэн сарын мэдээг хууль журамд заасан хугацаанд нь үнэн зөв гаргаж улсын ахлах бүртгэгч буюу тасгийн даргаар хянуулан тайлант хугацаанд нийт 10 удаа хүргүүлэн ажиллаад байна.<br>Мөн үнэт цаасны мэдээг 10 удаа гарган хэлтсийн нярав, нягтлан нарт хүлээлгэн өгсөн. | 01-11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах** | | | | | | | |
| 5.1 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх | Хүлээн авсан өргөдлийн тоо | 2 | 1 | ✓ Иргэн Л.Бадамцэцэг - 1 | 01-11 | 100% |
| | | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | ✓ 100% | | |
| 5.2 | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чандлан баримтлах | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чандлан баримталж ажилласан хувь | 100% | 100 | ✓ Бүртгэлийн үйл ажиллагаанд иргэдээс ирүүлсэн гомдол санал байхгүй<br>✓ Эрүүл мэндийн шалтгаанаар 2 удаа эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн | 01-11 | 100% |
| 5.3 | Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал болон чиглэл зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | Ирүүлсэн тушаал болон чиглэл, зөвлөмж, шийдвэрийн тоо | 11 | 5 | **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 5/12510 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 358 дугаар тогтоолоор "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.7 дахь заалт хүчингүй болсонтой холбогдуулан дуусаагүй барилгаар эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, бүхэлдээ барьцааны эрх бүртгэлтэй байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагч нарын өмчлөлд хэсэгчлэн шилжүүлж эрхийн улсын бүртгэлд тусад нь салгаж бүртгэхдээ тус чиглэлийг мөрдөн ажиллаж байна.<br>**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/655, 2024 оны 02 дугаар сарын 20-ны** | 01-11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **өдрийн 5/2170 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**<br>Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Хяналт шалгалтын газраас бүртгэл хөтлөх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтэд шалгалт хийх явцад илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч дахин зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 5/2366, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 5/4803 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**<br>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт "газрын эрх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ" гэж эрхийн улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлж өгсөн байна. Иймд ЭУБ-06 маягтийг үйлдэхдээ барьцаа хөрөнгийн мэдээлэл хэсгийн бусад гэсэн талбарт барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнийг дурдан иргүүлж байхыг мэдэгдэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Нотариат, банк, банк бус | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүгийн байгууллагатай хамтарсан уулзалт зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн сургалтын зааланд зохион байгуулж ажилласан.<br>**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 5/2717 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Голомт банк, "Монголын ипотекийн корпораци" ХХК-иас барьцаат зээлийн гэрээ бүртгүүлэх, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээг дундын мэдээллийн сангаар дамжуулан /ePRS/ системд "Онлайн мэдүүлэг" цэсэнд цахимаар илгээн бүртгэхтэй холбоотой 3 бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.<br>**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 5/6203 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл авсан иргэн, хуулийн этгээд нь төлбөрөө төлж барагдуулаагүй тохиолдолд зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах тухай албан бичигт дурдсаны дагуу улсын ахлах бүртгэгч танилцуулж бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>Тус чиглэл ирүүлсэн өдрөөс хойш болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус бүртгэлийн үйлчилгээг авахаар Баянхонгор | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | аймгийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт мэдүүлэг гаргаагүй байна.<br>**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/110 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийг үндэслэн өөрчлөгдсөн маягтын загварын дагуу 178 бүртгэлийг бүртгэн баталгажжуулсан байна.<br>**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хяналт шалгалтын газрын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 91 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн санал авах тухай албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Дээрх албан бичгийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр дараах саналыг хүргүүлж ажилласан. Үүнд:<br>1. Үйлчилгээний төрөл сольж болдог байх<br>2. Яаралтай төлөв хасах<br>**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын эрх зүйн хэлтсээс 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 2-1/12503 тоот албан бичиг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын** | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | **даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/167 дугаарт тушаалын хэрэгжилтийн талаар:**<br>Ипотек болон /Барьцаа/-ийн бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд ажлын нэг өдөр буюу мэдүүлэг гаргасан даруйд нь нийт 913 бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.<br>**Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 1/12638 дугаарт албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Дээрх албан бичгийн дагуу бүртгэлийн үйлчилгээг авахад хүндрэлтэй ажлын ачаалал ихтэй цэцэрлэг, сургууль, цэргийн анги, цагдаагийн байгууллагын албан хаагч нарт хүрч үйлчлэх зорилгоор байгууллагуудад нь хүсэлт хүргүүлж хуваарийн дагуу ажлын байранд нь очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан.<br>**Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 9/12988 дугаарт албан бичгийн биелэлтийн талаар:**<br>Дээрх албан бичгээр ирүүлсэн "Хүүхдийн төлөө" аяны удирдамжийн дагуу хэлтсийн хамт олонтойгоо тус аянд нэгдсэнээ илэрхийлж гарын үсгээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулан хэлтсийн даргаар дамжуулан хүргүүлсэн. | | |
| | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | ✓ 100% | | |
| 5.4 | Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгуулах | Нээлтэй хаалганы өдөрлөг зохион байгуулахад оролцсон эсэх | 2 | 1 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 1/12638 дугаарт албан бичгийн дагуу бүртгэлийн үйлчилгээг авахад хүндрэлтэй ажлын ачаалал ихтэй цэцэрлэг, сургууль, цэргийн анги, цагдаагийн байгууллагын албан хаагч нарт хүрч үйлчлэх зорилгоор байгууллагуудад нь хүсэлт хүргүүлж хуваарийн дагуу "Номгон" ахлах сургуулийн ажлын байранд нь очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан. | 01-11 | 100% 70% |
| 5.5 | Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд гаргах | Нууцын баталгаа өгсөн эсэх | 1 | 1 | ✓ Нууцын баталгаагаа хугацаанд гаргаж өгсөн. | 01-11 | 100% |
| **6. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 6.1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд нь гаргаж холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлэх, | 2024 оны ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж хугацаанд нь батлуулах, хэрэгжилтийг хугацаанд нь хангаж ажилласан эсэх | 97% | 40% | 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж хэлтсийн даргаар батлуулсан. | 01-11 | 100% |
| | | ХАСХОМ-ыг хугацаанд нь мэдүүлж баталгаажуулсан эсэх | 1 | 1 | 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөж хэлтсийн даргаар хянуулан баталгаажуулж хуулийн хугацаанд нь гаргасан. | 01-11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрийн албан хаагчийн татварын тайланг хугацаанд нь гаргасан эсэх | 1 | 1 | 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Төрийн албан хаагчийн татварын тайланг хүргүүлсэн. | | |
| **Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| **д/д** | **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** |
| | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | **Суурь түвшин** | **Хүрэх түвшин** | **Хүрсэн түвшин (Биелэлт)** | **Эхэлсэн дууссан хугацаа** | **Биелэлтийн хувь** |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, УБЕГ, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулах сургалтад цахимаар болон тахимаар хамрагдах. | Сургалтад онлайнаар хамрагдсан хувь | 95% | 100% | 1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа 7:4:10 Вебинар сургалтад 2024 оны 03 дугаар 07-ны өдрөөс эхлэн онлайнаар 22 удаа,<br>2. УБЕГ-аас болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтад онлайнаар 3 удаа,<br>3. АЗДТГ-аас зохион байгуулсан сургалтад танхимаар 3 удаа,<br>4. 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс гэр бүлийн хөгжлийг дэмжих жилтэй холбогдуулан Монгол улсын гавьяат багш доктор, дэд профессор Х.Баавгайн "Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо" сэдэвт сургалтад бүртгэгч С.Баярмаа, Э.Адьяабаяр нарын хамт хамрагдсан<br>5. Бусад төрийн болон төрийн бус байгууллагын сургалтад 4 удаа тус тус хамрагдсан.<br>6. 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдөр УБЕГ-ын даргын тушаалаар МУИХ-ын 2024 оны | 01-11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнуудын "Эрх зүй, мэдээлэл технологийн сургалт"-д хамрагдсан.<br>7. 2024 оны 08 дугаар сарын 14-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан бүсчилсэн нэгдсэн сургалтыг Дорнод аймагт зохион байгуулж хэлтсийн албан хаагчдын хамт оролцсон.<br>8. 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр УБЕГ-аас СБД-ийн ХГБХХХхэлтсээс мэргэжилтэн Л.Дэлгэрсайханы "Гэр бүл төлөвлөлт ба хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад онлайнаар хамрагдсан. | | |
| | | Сургалтад танхимаар хамрагдсан хувь | 95% | 100% | ✓ 100% | | |
| 2 | Монгол бичгийн болон зөв бичих дүрмийн мэдлэгээ бататгаж сайжруулах, монгол бичгээр компьютерт шивж сурсан байх | Суралцсан кредит цаг | 17 кредит цаг | 20 кредит цаг | 1. Төрийн албаны зөвлөл болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс төрийн албан хаагчын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судлагаанд танхимаар 1, онлайнаар 1 удаа хамрагдсан.<br>2. 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах ажлын хүрээнд хамт олноороо монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. | 04-11 | 80% |
| | | Монгол бичиг, криллээр хосолж бичсэн албан бичгийн тоо | - | 3 | ✓ Монгол бичиг, криллээр хосолж бичсэн албан бичгийн тоо - 3 | 01-11 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | Суралцсан кредит цаг | - | 8 кредит цаг | Удирдлагын академийн "Удирдах албан тушаалтны манлайлал" сэдэвт 32 цагийн сургалтанд 2024 оны 18,19-ны өдрүүдэд танхимаар хамрагдахаар бүртгүүлсэн. | 01-11 | 50% | |
| 4 | Хэлтсийн албан хаагч нарт "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь" сэдэвт сургалтыг үе шаттайгаар үргэлжлүүлэн зохион байгуулах , Жендэрийн мэдрэмжтэй байгууллага болох | Сургалтын тоо | 3 | 2 | 1. "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ы хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 2/11313 тоот "Биелэлт ирүүлэх тухай" албан бичгийн дагуу "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг хөвгүүд, эрчүүдийн оролцоог хангах замаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэж, хүчирхийллийг таслан зогсоох, түүнчлэн урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжид заасан санаачлагыг дэмжин, дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:<br>➢ Хэлтсийн бүх албан хаагч аянд нэгдэж байгаагаа илэрхийлсэн зурагт хуудсыг хэлтсийн сайт дээр байршуулж нийт албан хаагчдаар facebook хуудсаар нь дамжуулан олон нийтэд түгээсэн ба **3 264** хандалт авсан байна.<br>➢ Жендэрийн Үндэсний хорооны цахим хуудсанд аянд нэгдэж байгаа зурагт хуудсыг байршуулсан.<br>➢ Жендэрийн Үндэсний хорооноос өөрийн сайтаараа | 01-11 | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дамжуулан хүргэж байгаа "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян" уриатай зурагт хуудсыг хэлтсийн сайтад байршуулан share хийж нийт 11 удаагийн мэдээллийг олон нийтэд түгээн ажиллав.<br>➢ 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн н.Ганбаяртай хамтран ерөнхий боловсролын "Номун далай" цогцолбор сургуулийн 10д ангийн сурагч нарт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүднээс охид, хөвгүүдийн оролцоог хангах замаар "Тамхины хор уршиг", "Гэмт хэрэг зөрчлийн тухай ойлголт", "Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх", "Цахим орчинд хүүхдийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх" гэсэн сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.<br>➢ 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хэлтсийн нийт албан хаагч нарт танхимаар, сумын албан хаагч нарт онлайнаар "Жендэрийн мэдрэмжтэй төрийн байгууллага" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. “Нэг тэрбумаараа тэмцье 2024” арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилтийн тайлан 2024 оны 03 сарын 11 өдөр хүргүүлсэн. Үүнд:<br>Охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг эсэргүүцэх, тэдний эдийн засаг, сэтгэл санаа, бие мах бод, бэлгийн эрх чөлөө хэрхэн зөрчигдөж буй, үүнийг таслан зогсооход нийгмийн ойлголт, хандлага, мэдлэгийг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, иргэдийн утга учиртай оролцоогоор дамжуулан хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцэх үндэсний хөдөлгөөнийг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа удирдамжийн дагуу манай байгууллага нь дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:<br>➢ Охид эмэгтэйчүүд, олон нийтэд жендэрт суурилсан хүчирхийлэл гэж юу болох хэрхэн урьдчилан сэргийлэх талаар Баянхонгор аймгийн залуучуудын Хөгжлийн төв, “Хөөрхөн зүрх” ТББ-аас бэлдсэн 6 төрлийн постор, зурагт хуудсыг өөрийн хэлтсийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн.<br>➢ Хэлтсийн албан хаагчид “Нэг тэрбумаараа тэмцье 2024” арга хэмжээнд өөрсдийн фэйсбүүк нүүр хуудсаа сольж охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бүхий л | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрлийн хүчирхийллийг хамтдаа таслан зогсоохыг уриалж цахимаар нэгдэж байгаагаа илэрхийлэн ажилласан 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр хэлтсийн албан хаагчдийн нэгдсэн сургалт дээр нийт албан хаагч нарт Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн н.Жавзмаа урин ээлжит сургалтыг зохион байгуулсан.<br>3. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1а/38 тоот албан бичиг ирүүлсэний дагуу "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт, төсөвлөлт" сэдэвт сургалтад хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал, Хяналтын байцаагч Л.Мэндбаяр, бүртгэгч Т.Мягмарсүрэн, архивч Дашням, сүлжээний инженер Доржнямбуу, бичиг хэрэг Ичинхорлоо, үйлчлэгч Болормаа нарын хамт хамрагдсан.<br>4. 2024 оны 04 дүгээр сарын 15-аас 19-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн 5 дугаар цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах үнэлгээний багт цэцэрлэгийн удирдлага болон хамт олны саналаар ажлаас чөлөөлж өгөх албан бичиг ирсэний дагуу хэлтсийн даргын зөвшөөрөлтэй цэцэрлэгийн эцэг эхийг төлөөлөн хамрагдаж ажилласан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5. Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 94 тоот албан бичгээр "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс төрийн байгууллагын дотоод журамд хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг тусгах чиглэлээр аргачлал боловсруулж ирүүлсэнийг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамтай харьцуулан үйл ажмллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>6. УБЕГ-ын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 2-1/9079 дугаарт албан бичгийн лагуу УБЕГ-ын Жендэрийн дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал байхгүй талаар 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр s.ambaselmaa@burtgel.gov.mn хаягаар хариу хүргүүлэв.<br>7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдөр ирүүлсэн "Хэрэгжилтийг ханган ажиллах тухай" албан бичиг ирүүлсэний дагуу төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг өөрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>8. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 2/13656 тоот "Зөвлөмж хүргүүлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай" албан бичгийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгааны дүн болон хуулийн хэрэгжилтийг хангах талаар ирүүлсэн санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | | |
| | | Албан хаагчдын сургалтад хамрагдсан хувь | 100% | 100% | ✓ 100% | | |
| | | Болзол хангасан хувь | - | 30% | ✓ 30% | | |
| 5 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан банк, банк бус санхүүгийн байгууллагын албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах | Сургалтын тоо | 0 | 1 | 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа банк, банк бус санхүүгийн байгууллагатай хамтын үйл ажиллагааг сайжруулах хамтарсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан. | 01-11 | 100% |
| 6 | Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг болон улсын комиссын дүгнэлт гаргадаг эрх бүхий иргэн, хуулийн этгээд, аж ахуй нэгжтэй хамтран ажиллах, санал солилцох сургалт зохион байгуулах | Сургалтын тоо | 0 | - | 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Баянхонгор аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт аймгийн хэмжээнд барилгын үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээд болон улсын комиссын дүгнэлт гаргадаг эрх бүхий албан тушаалтнуудтай хамтын үйл ажиллагааг сайжруулах, санал солилцох, нэгдсэн нэг ойлголтод хүрэх зорилготой хамтарсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах хүсэлэй байна. Иймд боломжит хугацаагаа товлон хариу ирүүлнэ үү гэсэн хамтран ажиллах тухай албан бичиг явуулсан боловч өнөөдрийн албан ёсоор хариу ирүүлээгүй байна | 01-11 | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 7 | Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөхтэй холбоотой анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн тоо | - | 10 | Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөхтэй холбоотой өгсөн анхан шатны зөвлөгөө мэдээлэл - 15 | 01-11 | 100% |

78%

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсувд 2024.11.12

УЛСЫН БҮРТГЭГЧ 102

66,1
14,26
6
74
93,76

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч (*албан тушаалын нэр)*
Архиагийн Оюунсувд (*албан хаагчийн овог, нэр*)-ын
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Нэгжийн нэр: Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн , ил тод нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна....... хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. .............................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 2.3. | 59,52 | 10 | 69,52 | |
| 4. | Арга хэмжээ 2.4. | 30 | 10 | 40 | |
| 5. | Арга хэмжээ 2.5. | 53,4 | 10 | 63,4 | |
| **Зорилт 3. .............................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| Зорилт4.-ийг **хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. | 54 | 10 | 64 | |
| 2. | Арга хэмжээ 4.2. | 60 | 10 | 70 | |
| 3 | Арга хэмжээ 4.3 | 60 | 10 | 70 | |
| 4 | Арга хэмжээ 4.4. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 5. .............................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 5.1. | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 5.2. | 54 | 10 | 64 | |
| 3 | Арга хэмжээ 5.3 | 54 | 10 | 64 | |
| 4 | Арга хэмжээ 5.4. | 42 | 10 | 52 | |
| 5 | Арга хэмжээ 5.5. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 6. .............................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 6.1 | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| | | | | | |
| **Дундаж оноо:** | | | | 66,1 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | 100 | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2. | 100 | 15 | |
| 3. | Арга хэмжээ 3. | 100 | 15 | |
| 4 | Арга хэмжээ 4. | 90 | 13,5 | |
| 5 | Арга хэмжээ 5. | 100 | 15 | |
| 6 | Арга хэмжээ 6. | 100 | 15 | |
| 7 | Арга хэмжээ 7. | 75 | 11,25 | |
| **Дундаж оноо** | | | 14,26 | |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 6 | |

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7,5 |
| 2. | Багаар ажиллах | 7,5 |
| 3. | Харилцаа | 7,4 |
| **Дундаж оноо** | | 7,4 |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(66,1 оноо)* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(14,26оноо)* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(6 оноо)* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | *(7,4 оноо)* |

| | | |
|---|---|---|
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 93,76 оноо |

***Үнэлгээ өгсөн:***

Хэлтсийн дарга
*(албан тушаал)*

***Нэгжийн дарга***

.................. /Ш.Мөнхтөгөлдөр/
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.06 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

Үйлчилгээ бүртгэгч
*(албан тушаал)*

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

.................. /А.Оюунжаргал/
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.09 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Хянатлан шалгах байцаагч
*(албан тушаал)*
.................. *(гарын үсэг)*
/Л.Мэндбаяр/ *(албан хаагчийн нэр)*
2024.12.09 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

НЯБО
*(албан тушаал)*
.................. *(гарын үсэг)*
/Г.Бат-Очир/ *(албан хаагчийн нэр)*
2024.12.09 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

Хэлтсийн дарга
*(албан тушаал)*

***Төсвийн шууд захирагч***

.................. /Ш.Мөнхтөгөлдөр/
*(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*
2024.12.09 *(огноо)*